

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025  
ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН “ТАЙЛАНГИЙН МАЯГТ”<sup>1</sup>**

<b>НЭГ. Товч танилцуулга<sup>2</sup></b>
<p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд нийт 33 Ёс зүйн дэд хороод 5-7 гишүүнтэйгээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/260 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Ёс зүйн дэд хороо”, Эрүүгийн цагдаагийн албаны даргын 2025 оны А/49, Мөрдөн байцаах албаны даргын 2025 оны А/40, Хэрэг бүртгэх албаны даргын 2025 оны А/03, Тээврийн цагдаагийн албаны даргын 2025 оны А/32, Урьдчилан сэргийлэх албаны даргын 2025 оны А/10, Экологийн цагдаагийн албаны даргын 2025 оны А/20, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын 2025 оны А/27, Стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны даргын 2025 оны А/33, Дотоодын цэргийн штабын даргын 2024 оны А/67, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн даргын 2025 оны А/20, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын 2025 оны А/63, Архангай аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/59, Баянхонгор аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/55, Баян-Өлгий аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/68, Булган аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/66, Говьсүмбэр аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/48, Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/52, Дорноговь аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/236, Дорнод аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/112, Дундговь аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/47, Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/59, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/61, Төв аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/07, Увс аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/100, Хөвсгөл аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/01, Хэнтий аймгийн цагдаагийн газрын даргын 2024 оны А/80, Ховд аймгийн цагдаагийн газрын даргын 2025 оны А/07 дугаар тушаалаар тус тус салбар дэд хороод байгуулагдан ажиллаж байна.</p> <p>Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/427 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ёс зүйн дэд хороотой хамтран ажиллах аргачлал”, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Ёс зүйн дэд хорооны даргын 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Ёс зүйн дэд хорооны ажиллах дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.</p>
<b>ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар</b>
<b>2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён</b>
<b>Г</b>
<p>Энэ онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Ёс зүйн дэд хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:</p> <p>Ёс зүйн дэд хороодоос Монгол Улсын Ёс зүйн хороо, Хүний эрхийн Үндэсний комисс, Удирдлагын академи, Дотоод хэргийн их сургууль, Авлигатай тэмцэх газар, ХААИС болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Хувийн хариуцлага, байгууллагын соёл”, “Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн</p>

<sup>1</sup> Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

<sup>2</sup> Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

<sup>3</sup>

Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

хууль тогтоомж”, “Стратеги төлөвлөгөө боловсруулалт, гүйцэтгэлийн удирдлага, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, “Ёс суртахууны тухай ойлголт”, “Төрийн үнэт зүйл” /үнэ, цэн/, “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”, “Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Харилцаа хандлагыг дээшлүүлэх”, “Хүний эрхийн тухай ойлголт, мөн чанар, олон улсын стандарт”, “Үлгэрлэе, дуурайя”, “Ёс зүй ба ёс суртахуун”, “Алба хаагчийн бүтээлч сэтгэлгээ, шударга байдал, ёс зүйг дээшлүүлэх”, “Цагдаагийн албан хаагчийн харилцааны соёл”, “Хүнлэг харилцаа-Хүндлэгдсэн цагдаа”, “Хүний эрх ба хууль сахиулах үйл ажиллагаа”, “Амьдралд ойрхон харилцаа” зэрэг олон талт сургалт, соён гэгээрүүлэх ажиллагааг зохион байгуулж, алба хаагчдыг хамруулсан байна.

онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээр 28 удаагийн 432 цагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 21512 алба хаагч, ажилтныг хамруулсан.

Монгол Улсын Ёс зүйн хороотой хамтран “Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах, ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ашиглах, системд бүртгэсэн мэдээллийг хянах заавар зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах нь” сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулж, уг сургалтад цагдаа, дотоодын цэргийн 33 анги, байгууллагын 216 алба хаагчийг хамруулсан.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинэлэг хэлбэрээр зохион явуулсан ажил, арга хэмжээнээс дурдвал:

Алба хаагчдыг соён гэгээрүүлэх, ажлын алжаал бухимдлыг тайлах, иргэдтэй ёс зүйтэй хэрхэн зөв боловсон харьцах, ажил, ачааллаа хэрхэн тэнцвэржүүлэх тал дээр сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэлтэй хосолсон “Ухаарлын 9 хором” сэдэвт лекц концертыг сэтгэл зүйч, доктор Б.Наранбаатартай хамтран “Сүлд-соён гэгээрүүлэх хэлтэс”-ээс нийслэлийн 9 дүүргийн алба хаагчдад зориулан анх удаа найруулан тавьж хүргэх ажлыг зохион байгууллаа.

Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас “Хүний эрхийг хүндэтгэе, хангая, хамгаалъя” аяныг улсын хэмжээнд зохион байгуулж, “Хүний эрхийг хангая, хамгаалъя”, “Танд тусъя” сэдэвт мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын “Алба хаагчдын чөлөөт индэр” хаалттай группээр байгууллага, алба хаагчдад хүргэсэн.

Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны Ёс зүйн дэд хорооноос төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, бусад эрх зүйн актыг иргэд, олон нийтэд сурталчлах, алба хаагчдад нөлөөлөх зорилгоор “Мессеж аян”-ыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, 8.2 дахь заалтын хүрээнд шударга ёсны төлөө 10, хариуцлага ба манлайлал 10, ёс суртахуун ба багийн үнэт зүйлтэй холбоотой 10, нийт 30 “Мессеж” үгийг боловсруулж, 1 сарын хугацаанд өглөө бүр ажлын цаг эхлэх буюу 08.30 минутад байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилласан.

Тээврийн цагдаагийн албаны Ёс зүйн дэд хорооноос “Талархлын видео аян”-ыг өрнүүлж, алба хаагч бүр өөрийн талархаж явдаг, мөр зэрэгцэн ажиллаж байгаа алба хаагчдаа сэтгэлийн үгээ илэрхийлж буй видео бичлэгийг бэлтгэн дотоод хаалттай группэд байршуулж, 1570 хүний хандалт авсан, тухайн бичлэгийн сэтгэгдэл хэсэгт бусад алба хаагчдаа нээлттэй байдлаар талархлын үгээ чөлөөтэй бичих нөхцөлийг бүрдүүлэн өгч ажиллаж байна.

Экологийн цагдаагийн албаны Ёс зүйн дэд хорооноос нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц нөхцөл байдлын үед ажиллах сэтгэл зүйн 4 төрлийн видео зөвлөмж, 3 төрлийн гарын авлагыг бэлтгэн алба хаагчдад хүргэсэн.

Мэдээлэл, шуурхай удирдлагын төв болон Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр “Дэлхийн ёс зүйн өдөр”-ийг тохиолдуулан байгууллагын цахим группт “Дэлхийн ёс зүйн өдөр”-ийн талаар мэндчилгээг дэвшүүлж, “Ёс зүй болон ёс зүйтэй хүн” сэдэвт видео шторкийг бэлтгэн алба хаагчдад мэдээлэл хүргэх ажлыг тус тус зохион байгуулсан.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Ёс зүйн дэд хорооноос алба хаагчдын мэдлэг, ур чадвар сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр “Чөлөөт долгион” цуврал подкастыг бэлтгэн сургалтын хаалттай цахим группт байршуулан хүргэсэн.

Дотоодын цэргийн байгууллагын “Хамтдаа хөгжье-Хамтдаан бүтээе” аяны хүрээнд алба хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор Монгол улсын их сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн оюутнуудтай хамтран “Сэтгэл тайван-Бие эрүүл алба хаагч” сэтгэл зүйн өдөрлөгийг зохион байгуулж, “Art therapy”, “Эерэг үг”, “Хайрын таван хэл” судалгаа, “Талархлын самбар”, “Номын булан” сэдвээр сургалтыг хүргэж ажилласан. Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын Ёс зүйн хорооноос байгууллагын үйл ажиллагаа болон алба хаагчийн ёс зүйтэй холбоотой санал хүсэлт авах хайрцгийг дотооддоо, QR кодыг цагдаагийн газрын пэйж хуудсанд байршуулж, иргэдээс санал хүсэлтийг авч ажиллаж байна.

Мөн тус хорооноос алба хаагчдын дунд дунд сахилга, ёс зүйн зөрчил гаргаж буй үндсэн гурван асуудлын хүрээнд илтгэлийн тэмцээн зохион байгуулж, алба хаагчийн өнцгөөс болон албан байгууллагын зүгээс асуудлын шалтгаан нөхцөлийг тодорхойлох, гарц гаргалгаа шийдлийг хэрхэн олох талаар хэлэлцүүлсэн. Илтгэлийн тэмцээнээр дамжуулан алба хаагчдыг шинэ сэтгэлгээ, дадал зуршлыг төлөвшүүлэх зорилготой бөгөөд асуудлаа танин мэдэж өөртөө дүгнэлт хийж, хувийн зохион байгуулалтаа сайжруулах олон талын ач холбогдолтой ажил болсон.

Архангай аймгийн цагдаагийн газрын Ёс зүйн дэд хорооноос Дотоодын цэргийн 831 дүгээр тусгай салбартай хамтран алба хаагчдын сахилга, ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах ёс зүйн аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлэхэд чиглэгдсэн “Ethic guide” арга хэмжээг зохион байгуулсан.

Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын Ёс зүйн дэд хорооноос сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын ахуй амьдралтай нь танилцан гэр бүлийн гишүүдтэй уулзах, ёс зүйн зөрчил гаргаж буй шалтгаан нөхцөлийг тогтоох, дахин давтан гаргуулахгүй байх, алба хаагчдад болон хариуцсан тасаг, нэгжийн даргад заавар, зөвлөмж өгсөн. Мөн ёс зүйн зөрчил давтан гаргаж болзошгүй, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй, согтууруулах ундааны хамааралтай байх эрсдэл бүхий 3 алба хаагчийг, гэр бүлийн гишүүний хамт Цагдаагийн газрын сэтгэл зүйчтэй уулзуулан сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлж хяналтын асуулга зохион байгуулсан. Зөвлөгөөний явцад гэр бүлийн харилцаа, хямралын үе шат түүнийг даван туулах, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх талаар зөвлөгөөг өгч ажилласнаар тухайн 3 алба хаагчаас сахилга, ёс зүйн зөрчил давтан гаргаагүй байна.

Дорноговь аймгийн цагдаагийн газрын Ёс зүйн дэд хорооноос “АЛХАМ АЛХМААР УРАГШИЛ” сэдэвт “Мэндчилгээний өдөр”, “Бахархлын өдөр”, “Талархлын өдөр”, “Хүндэтгэлийн өдөр”, “Уучлалын өдөр” 5 өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

“Төрийн алба хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030/-ийг хэрэгжүүлэх чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд 4 дэд сэдэв, 37 заалтын хүрээнд хэрэгжилт, үр дүнг нэгтгэж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 01/1137 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

## **2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:**

Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас хууль, журамд заасны дагуу Ёс зүйн дэд хороодыг бие даасан, хараат бус зарчмаар ажиллахад дэмжлэг үзүүлэх, тэднийг ажиллах нөхцөл боломжоор хангах, тус хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд урамшуулал олгох, чадавхжуулах зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх талаар холбогдох чиглэлийг харьяа албад, нэгжийн дарга нарт хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Ёс зүйн дэд хорооноос цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас Ёс зүйн дэд хороотой хамтран ажиллах үйл ажиллагааг журамласан зохицуулалтыг боловсруулж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд нэмэлт оруулан, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/427 дугаар тушаалаар батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийн талаар удирдах ажилтнуудын дунд нэгдсэн ойлголт бий болгох, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулж, үр дүнд хүрсэн улс орнуудын туршлага, дэлхий нийтийн чиг хандлагаас суралцах, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, цаашдын бодлого зорилтоо тодорхойлох зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2025 оны удирдах

ажилтны нэгдсэн зөвлөгөөн"-ийг "Хамтдаа хөгжье" уриа дор зохион байгуулсан. Тус зөвлөгөөний үеэр Монгол Улсын Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс "Төрийн албан хаагчийн ёс зүйн бодлого, хууль, эрх зүйн орчин" сэдвээр удирдах албан тушаалтнуудад сургалт, мэдээлэл хийсэн байна.

Монгол Улсын Ёс зүйн хороотой хамтран "Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах, ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ашиглах, системд бүртгэсэн мэдээллийг хянах заавар зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах нь" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулж, уг сургалтад цагдаа, дотоодын цэргийн 33 анги, байгууллагын 216 алба хаагчийг хамруулсан.

Засгийн газрын Ёс зүйн хорооноос 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр төрийн ордонд зохион байгуулагдсан яамдын Төрийн нарийн бичгийн дарга болон агентлагийн дарга нарын ёс зүйн сургалт, мэдээлэлд ЦДЦБ-ын Ёс зүйн дэд хорооны дарга оролцож, Засгийн газрын Ёс зүйн хорооны даргаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар 02 дугаартай танилцуулгыг боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Ёс зүйн салбар дэд хороодод хүргүүлэн хэрэгжилт, үр дүнг тооцож ажилласан.

Энэ оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан Нийслэлийн бүсийн "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" сэдэвт зөвлөгөөнд 1 гишүүн оролцож, тус зөвлөгөөний үеэр хэлэлцсэн "Төрийн албаны шинэтгэл-Ёс зүй" сэдвийн талаар Ёс зүйн дэд хорооны гишүүдэд мэдээлэл өгч ажилласан.

Улсын Их хурын Тамгын газраас 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан "Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл" бүлгийн ярилцлагад тус хорооны 1 гишүүн оролцсон.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга ирүүлсэн 4/551 дугаартай албан бичгийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ёс зүйн дэд хорооны даргаас энэ оны 08 дугаар сарын 01-ний өдрийн ЁЗДХ/11 дугаартай "Зөвлөмж"-ийг 32 алба, газар, ангид хүргүүлж, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан.

Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн удирдлагаас санаачлан хамт олны дунд эерэг харилцааг бүрдүүлэх, удирдах албан тушаалтны удирдлагын арга барилыг сайжруулах ажлын хүрээнд "Бидний тухай", "Чиний тухай", "Чиний дүр" зэрэг сэдвүүдээр бүлгийн сургалтыг зохион байгуулсан.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Канад Улсуудаас хэрэгжүүлж үр дүнд хүрсэн тэргүүн туршлага болохуйц ажил, арга хэмжээнүүдийн талаар судалж, удирдлагын хэмжээнд 2 удаа танилцуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллага бүр улирал, хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны тайлангийн хурал, сахилгын зөвлөгөөнийг зохион байгуулж хэвшсэн бөгөөд тус зөвлөгөөний үеэр цагдаагийн байгууллагад 10-аас дээш жил ажиллах хугацаандаа сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргаж байгаагүй алба хаагчдыг урамшуулах, хамт олны өмнө алдаршуулах, урамшуулах, ажлын туршлагыг хуваалцах зэрэг байдлаар соён гэгээрүүлэх, манлайлах, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол явуулан ажиллаж байна.

### **2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд нийт 33 Ёс зүйн дэд хороод 5-7 гишүүнтэйгээр байгуулагдан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр Ёс зүйн дэд хороод нь алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн эрсдэлийг бууруулах, соён гэгээрүүлэх, зөвлөмж өгөх, хяналт-шинжилгээ хийх чиглэлээр төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлж, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажилласан.

Цаашид ёс зүйн хууль, журам, тогтоолын хэрэгжилтийг хангах, алба хаагчдын хариуцлага, сахилга, ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, дээд шатны байгууллагад

тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулах чиглэлээр анхааран ажиллаж байна.

2025 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчтай холбоотой **2108** өргөдөл, гомдол хүлээн авч, **2294** алба хаагчид холбогдсон нь урд оны мөн үеэс өргөдөл, гомдол 336 буюу **14** хувь, холбогдон шалгагдсан алба хаагч 517 буюу **18** хувиар тус тус буурсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга ирүүлсэн 4/551 дугаартай албан бичгийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ёс зүйн дэд хорооны даргаас энэ оны 08 дугаар сарын 01-ний өдрийн ЁЗДХ/11 дугаартай “Зөвлөмж”-ийг 32 алба, газар, ангид хүргүүлж, хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан.

Эрүүгийн цагдаагийн албанаас алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн илрүүлэлт шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 104 зөвлөмж,

Гэмт хэрэг, зөрчил шалгах албанаас алба хаагчид үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлгүй хандах зөрчил ихээр гарч байгаатай холбогдуулан харьяа нэгжийн тасгийн дарга нарт 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 17а/2594 дугаартай “Зөвлөмж” хүргүүлж, үр дүнг тооцож ажилласан.

Экологийн цагдаагийн албаны Ёс зүйн дэд хорооноос алба хаагчдаас иргэдтэй харилцах үед гаргаж буй нийтлэг алдаа дутагдал болон “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм” “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2D/цахим анимейшныг бүтээж байгууллагын дотоод хаалттай группээр дамжуулан танилцуулсан.

ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Канад Улсуудаас хэрэгжүүлж үр дүнд хүрсэн тэргүүн туршлага болохуйц ажил, арга хэмжээнүүдийн талаар судалж удирдлагад танилцуулж ажилласан. Тус албанаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны санхүүжилтээр алба хаагчдыг нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед болон хэргийн газрын хамгаалалтад ажиллах зэргээр албан үүргээ гүйцэтгэх үедээ сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдэлт нөхцөл байдалд сэтгэл зүйг бэлтгэх зорилгоор “Сэтгэл зүйн виртуал танхим”-ыг үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна.

Энэ оны эцсийн байдлаар Ёс зүйн 33 дэд хорооноос 11 нь урамшууллыг бүрэн, 12 нь дутуу, 10 нь огт олгоогүй байна. Санхүүжилтгүй гэх шалтгаанаар Цагдаа, дотоодын цэргийн ёс зүйн дэд хороо болон зарим алба, аймгийн цагдаагийн газрууд урамшуулал олгоогүй бол Дотоодын цэргийн штаб болон зарим аймаг 1–3 улиралд бүрэн олгосон байна.

<b>Гарсан үр дүн, ололт амжилт:</b>	<b>Бэрхшээл:</b>
Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдлага болон Ёс зүйн дэд хороодоос 2025 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор олон талт ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчтай холбоотой өргөдөл, гомдол 336 буюу 14 хувь, холбогдон шалгагдсан алба хаагч 517 буюу 18 хувиар урьд оны мөн үеэс тус тус буурсан эерэг үр дүнтэй байна.	Төрийн албаны ёс зүйн хорооноос цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах, сурган дадлагажуулах чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамруулах мэдээллийг ирүүлдэггүй.

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО